



**ТӨРИЙН ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 03 сарын 30 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

**Гүйцэтгэх захиралтай байгуулсан  
Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний  
биелэлтийг дүгнэх тухай**

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.9 дэх заалт, “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.3.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 184 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн захиралтай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам”-д заасан шалгуур үзүүлэлтийн дагуу 84,3 хувийн үнэлгээ авсан тул Гүйцэтгэх захиралтай 2022 онд байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг хавсралт ёсоор “Хангалттай” гэж дүгнэсүгэй.

2. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, Гүйцэтгэх захиралтай байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлөөс гарсан шийдвэрийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэхийг Гүйцэтгэх захирал /Л.Батжаргал/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ц.ШИНЭХҮҮ

“Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн Гүйцэтгэх захиралтай  
байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг дүгнэх үзүүлэлт /2022 он/

№	Дүгнэх үзүүлэлт	Үнэлгээнд тавих оноо				
		2022 оны төлөвлөгөө	2022 оны биелэлт	Авбал зохих оноо	ТУЗ-ийн дүгнэлт	ТӨБЗГ-ын дүгнэлт
<b>1</b>	<b>Нэг. Эдийн засгийн үзүүлэлт</b>			<b>55</b>	<b>45</b>	
1.1	Борлуулсан объект	542	627	5	5	
1.2	Нийт орлого	8,168.9 сая	8,958,5 сая	10	10	
1.3	Нийт зардал	8,159.7 сая	9,798,5 сая	5	4	
1.4	Цэвэр ашиг/алдагдал	8.2 сая	(840.0 сая)	10	5	
1.5	Борлуулалтын орлогын 1 төг-т ногдох зардал	0.999	1.000	5	5	
1.6	Нийт авлага	91,245.9 сая	114,823.5 сая	5	4	
1.7	Нийт өглөг	231,541.8 сая	262,258.5 сая	5	3	
1.8	Хөрөнгө оруулалт	Түр суурьшуулах зардал 249.6 сая, Хөрөнгө худалдан авалт 32.1 сая төг	Түр суурьшуулах зардал 188.3 сая, Хөрөнгө худалдан авалт 25,2 сая төг	5	4	
1.9	Төрийн өмчийн ногдол ашгийн гүйцэтгэл улс, орон нутгийн төсөвт өр төлбөргүй байх	Ашиггүй, Харьяа дүүргийн татварын газар болон бусад холбогдох байгууллагуудад өр төлбөргүй ажиллаж байна.		5	5	
<b>2</b>	<b>Хоёр. Тайлангийн үр дүн</b>			<b>45</b>	<b>39,3</b>	
2.1	Тухайн жилийн тайлан тэнцлийн аудитын дүгнэлт, сүүлийн 2 жилийн зөвлөмжийн хэрэгжилт	2021 оны аудитын дүгнэлтээр нийт 7 албан шаардлага, 4 зөвлөмж өгч, 1 төлбөрийн акт тогтоогдсон. Нийт 4 зөвлөмж 100% биелэлттэй, 6 албан шаардлага 77%-ийн биелэлттэй, төлбөрийн акт 100% биелэлттэй. Нийт 92% биелсэн байна.		5	4,6	
2.2	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар болон ТУЗ-ийн шийдвэрийн биелэлт	ТӨБЗГ-аас ирүүлсэн үүрэг чиглэлийн дагуу авсан арга хэмжээ, биелэлтийг тухай бүр тогтоосон хугацаанд нь албан бичгээр хариу тайлагнасан. 2022 онд ТУЗ-аас 21 тогтоол гарсан бөгөөд хэрэгжилт 78.4%-тай байна.		5	3,9	
2.3	Худалдан авах ажиллагааны тухай хууль, Шилэн дансны хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн биелэлт	Нийт 25,2 сая төгрөгийн худалдан авалт, 188.3 сая төгрөгийн түр суурьшуулах зардал, бэлтгэл ажилд 60,9 сая, нийт 274,5 сая төгрөгийн зардал гарсан.  319,380.9 сая төгрөгийн 383 гүйлгээг байршуулахаас 300,359.0 сая төгрөгийн 228 гүйлгээг хугацаа хоцроож шилэн дансанд байршуулсан.		4	2	
2.4	Хэрэглэгчийн санал асуулгын дүн	2022 оны 12 дугаар сард байгууллагын нийт ажилтан, албан хаагч болон байгууллагаар үйлчлүүлж буй иргэд, хэрэглэгчдээс санал асуулга авсан.		3	3	
2.5	Ажиллагсдын санал асуулгын дүн			3	3	
2.6	Харьяалах салбарын яам, төрийн захиргааны холбогдох байгууллагын үнэлгээ /шийдвэрийн хэрэгжилт/	БХБЯ-ны 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 3/5973 тоот албан бичгээр гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж 91.4%-тай ТОДОРХОЙ ҮР ДҮНД ХҮРСЭН гэж дүгнэсэн.		25	22.8	
<b>НИЙТ ОНОО</b>				<b>100</b>	<b>84,3</b>	